

*Зам, тээврийн хөгжлийн сайдын
2019 оны 06 сарын 12-ны 187 тоот
тушаалын 08 дугаар хавсралт*



ИНД - 100

Иргэний Нисэхийн Дүрэм

Аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо

Иргэний нисэхийн ерөнхий газар

ДҮРМИЙН ТАЙЛБАР

ИНД-100-гийн зорилго нь иргэний нисэхийн байгууллагад үр дүнтэй Аюулгүй байдлын тогтолцоог нэвтрүүлж, хэвшүүлэх замаар Монгол Улсын нисэхийн аюулгүй байдлын үзүүлэлтийг сайжруулах, Монгол Улсын нэгдэн орсон Олон улсын Иргэний нисэхийн тухай Конвенцийн дагуу хүлээсэн үүргээ биелүүлж байгааг бататгахад оршино.

Энэ Дүрэм нь Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан ИНД-100-гийн цахим хувилбар бөгөөд зөвхөн ишлэл хийх зорилгоор хэрэглэнэ. Хүчин төгөлдөр ИНД-100, түүний нэмэлт, өөрчлөлтийн хуулбарыг ИНЕГ-аас, эсхүл www.mcaa.gov.mn веб сайтаас татаж авах боломжтой.

Мэдээлэл

Гишүүн улсуудын иргэний нисэхийн Дүрмийг сайжруулах замаар иргэний нисэхийн салбарт нэгдсэн нэг Дүрмийн зохицуулалтад шилжих Олон улсын иргэний нисэхийн байгууллагын 1992 оны 29-р чуулганы А29-3 тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор, Монгол Улс болон Шинэ Зеланд улсын ИНЕГ-ын хооронд 1999 оны 5 сарын 6-нд байгуулсан “Техникийн Хамтын Ажиллагааны Санамж Бичиг”-ийг үндэслэн Монгол Улсын Иргэний нисэхийн дүрмийг боловсруулсан.

Өөрчлөлтийн түүх

Анхны боловсруулалт

Хүчинтэй огноо

2019 оны 06 сарын 12

Тэмдэглэл: ИНД-100-гийн анхны боловсруулалтыг монгол, англи хэл дээр, NZ Part 100-гийн 2016 оны 02 сарын 01-ний А.0-д үндэслэн боловсруулсан болно.

Гарчиг

100.1. Хамрах хүрээ.....	1
100.3. Аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо	1

100.1. Хамрах хүрээ

Энэ Дүрэм нь, Иргэний нисэхийн дүрмээр Аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог бий болгох, хэрэгжүүлэх болон хадгалахыг шаардсан байгууллагад хамаарна.

100.3. Аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо

(a) Энэ Дүрэмд хамаарах байгууллага нь дараах шаардлагыг багтаасан Аюулгүй байдлын удирдлагын тогтолцоотой байх үүрэгтэй:

- (1) Аюулгүй байдлын удирдлагын тогтолцоонд суурилсан Аюулгүй байдлын бодлого;
- (2) нисэхийн аюулгүй байдалд учрах аюулыг олж тогтоох, холбогдох эрсдэлийг үнэлэх болон удирдах эрсдэлийн удирдлагын үйл явц;
- (3) дараах шаардлагыг бататгах аюулгүй байдлын баталгаажуулалтын арга хэмжээ:
 - (i) аюул, зөрчил болон ослыг дотооддоо мэдээлэх, түүнд дүн шинжилгээ хийх, дахин давтагдахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авдаг байх;
 - (ii) нисэхийн аюулгүй байдлыг сайжруулах зорилтыг тогтоосон ба эдгээр зорилтын биелэлтийг хэмжиж дүгнэдэг байх;
 - (iii) дотоод аудит хийх болон Аюулгүй байдлын удирдлагын тогтолцоонд тогтмол дүгнэлт хийх ажиллагааг багтаасан чанар баталгаажуулалтын хөтөлбөртэй байх;
- (4) ажилтнууд нь аюулгүй байдлын үүрэг хариуцлагаа бүрэн хэрэгжүүлэх ур чадвартай болохыг бататгах сургалт.

(b) Тухайн байгууллага нь Аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог бий болгох, хадгалахад шаардлагатай бүх үйл явцыг баримтжуулсан байх үүрэгтэй.

(c) Тухайн байгууллагын Аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо нь байгууллагын хэмжээ, үйл ажиллагааны шинж чанар болон тухайн байгууллагын гүйцэтгэж байгаа үйл ажиллагааны төвөгшил, байгууллагын үйл ажиллагаатай салшгүй холбоотой аюул болон холбогдох эрсдэлд тохирсон байх шаардлагатай.

--oOo--